

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо<sup>8</sup> : 2022.03.04

Тендер шалгаруулалтын нэр: **Гаалийн байгууллагын зарим газар, хороодын урсгал засварын ажил гүйцэтгэх**

Тендер шалгаруулалтын дугаар: **ГЕГ/202201005**

**Гаалийн ерөнхий газар** нь тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан хуулийн этгээдийг **Гаалийн байгууллагын зарим газар, хороодын урсгал засварын ажил**-ыг гүйцэтгэх тухай тендер ирүүлэхийг урьж байна.

Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ:

**Багц № 1:** Гаалийн ерөнхий газрын шуурхай удирдлагын төв болон гаалийн төв лабораторийн барилгын цахилгааны аваарын нөхцөлд ажиллах генератор нийлүүлэх, угсрах, суурилуулах ажил.

**Багц № 2:** Дархан-Уул аймаг дахь гаалийн газрын барилгын гадна засвар.

**Багц № 3:** Замын-Үүд дэх гаалийн газрын албан хаагчдын орон сууцны барилгын дээврийн засвар, дотор дулаан, цэвэр бохир усны шугамын засвар.

**Багц № 4:** Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын албан хаагчдын орон сууцны барилгын дээврийн засвар.

Сонирхогч этгээд худалдан авах ажиллагааны цахим системээр тендерийн баримт бичигтэй үнэ төлбөргүй танилцах эрхтэй бөгөөд тендерийн баримт бичгийн үнийг төлснөөр тендер шалгаруулалтад оролцох эрхтэй болно.

Тендер нь түүнийг нээснээс хойш [30] ба түүнээс дээш хоногийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заах ба **Багц № 1: 3 223 000 төгрөг, Багц № 2: 3 200 000 төгрөг, Багц № 3: 5 860 000 төгрөг, Багц № 4: 1 360 000 төгрөг**-өөс багагүй үнийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.<sup>9</sup>

Тендерийг **2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 10 цаг 00 минутаас өмнө** тендерийн баримт бичигт заасан хэлбэрээр ирүүлэх ба тендерийн нээлтийг **2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 10 цаг 30 минутад** зохион байгуулна.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх:<sup>10</sup> **“Эрхгүй”**

Урьдчилсан худалдан авах ажиллагааны урилга эсэх: **“Үгүй”**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг доорх хаягаар хүргүүлж болно.

**Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Их тойруу, 81/1, Гаалийн ерөнхий газрын Шуурхай удирдлагын төвийн байр 608 тоот, Утас: 352775**

<sup>8</sup> Тендерийн урилгыг анх зарлан мэдээлсэн өдөр байна.

<sup>9</sup> 100 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй ажил, 70 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй бараа, зөвлөхөөс бусад үйлчилгээ худалдан авахад тендерийн баталгаа шаардана.

<sup>10</sup> Хуулийн 9.3-т зааснаас бусад тендер шалгаруулалтад гадаадын этгээдийг оролцуулж үл болно.